

Батлав



МУБИС-ийн БСС-ийн захирал, доктор (Ph.D), проф. Д.Мөнхжаргал

“Хүүхэд, залуучуудын хөгжил, төлөвшил: Асуудал, шийдэл, дэмжлэг” сэдэвт оюутны эрдэм шинжилгээний бага хурлын удирдамж

2024-09-30

Монгол улс “Алсын хараа – 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын **үндэсний бахархал эв нэгдлийн** хүрээнд өв тэгш, үндэсний ухамсарт эх оронч монгол хүнийг төлөвшүүлэх, дэлхийн **монгол** зорилтын хүрээнд Монгол хүн бүр үнэт зүйлээ эрхэмлэж, бусдаас ялгарах онцлог, давуу талаа дэлхий нийтэд таниулах, **хүний хөгжлийн** хүрээнд хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, боловсролыг хувь хүний хөгжил, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болгон насан туршдаа суралцахуйн тогтолцоог бэхжүүлэх, **эрүүл мэндийн** хүрээнд эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэх зорилтуудыг дэвшүүлсэн билээ. Улс орны хөгжил дэвшлийн урт хугацааны эдгээр зорилтыг хангах ажлын хүрээнд 2025 оныг Монгол улсын засгийн газар **“Залуучуудын жил”** болгон зарласантай холбогдуулан энэ удаагийн оюутны эрдэм шинжилгээний бага хурлыг **“Хүүхэд, залуучуудын хөгжил, төлөвшил: Асуудал, шийдэл, дэмжлэг”** сэдвийн хүрээнд зохион байгуулах гэж байна.

Нэг. Бага хурлын зорилго

Хүүхэд, залуучуудын хөгжил, төлөвшлийн өнөөдрийн байдалд үнэлгээ өгч, тэдний суралцах, нийгэмших, эрүүл аж төрөх үйл явцад тулгамдаж буй асуудлыг илрүүлэх, шийдвэрлэхэд оюутны үүрэг оролцоог нэмэгдүүлэх боломжийг эрэлхийлэхэд оршино.

Хоёр. Тавигдах илтгэлийн чиглэл

Ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын болон их, дээд сургуулийн суралцагч, хүүхдэд залуучуудын хөгжил, төлөвшлийн асуудлыг хөндсөн дараах чиглэлийн илтгэлүүдийг хүлээн авах болно. Үүнд:

- Их, дээд сургуулийн сургалтын чанар, түүнд оюутны эзэлж байгаа байр суурь
- Оюутны бие даах ажлын чанар, түүний оюутны хөгжилд оруулж буй хувь нэмэр
- Оюутны байгууллагуудын үйл ажиллагаа, түүний мэргэжилтэн-бие хүний төлөвшилд үзүүлж байгаа нөлөө
- Оюутны үнэт зүйл ба хандлагын төлөвшил, түүнд нөлөөлж буй хүчин зүйлс
- Хүүхэд, залуучуудын ёс суртахууны төлөвшил
- Дээд боловсролын шинэчлэл, түүний хэрэгжилтийн оюутанд өгч байгаа үр нөлөө
- Хүүхэд, залуучуудын уншиж судлах үйл ажиллагаа ба орчны дэмжлэг

- Номын сан (их сургуулийн, нийтийн) ба хувь хүний хөгжил
- Монгол хүүхдийн бие даан ажиллах чадварын төлөвшил
- Alpha, Zed үеийнхний онцлог, тэдний хөгжлийг дэмжих нь
- Өсвөр насны хүүхдийн үнэт зүйлийн чиг хандлага
- Орчин үеийн хүүхэд, залуучуудын чөлөөт цаг ба хувь хүний хөгжил
- Суралцагчдын хөгжлийг дэмжих үйл ажиллагаа, дугуйлан, секцийн үр нөлөө
- Өнөөдрийн хүүхэд, залуучуудын эрүүл мэндийн байдал
- Өөрөө удирдах байгууллага ба оюутны оролцоо, манлайлал
- Хүүхдийн хөгжил, төлөвшилд нөлөөлж буй хүчин зүйлс (сургууль, гэр бүл, үе тэнгийнхэн, нийгмийн сүлжээ, цахим орчин г.м)
- Хүүхэд, залуучуудын асуудал эрхэлдэг олон нийтийн байгууллагуудын үйл ажиллагааны өнөөдрийн төлөв байдал
- Бусад:

Жич: Дээрх сэдвүүд нь оролцогчдыг хурлын үндсэн сэдвийн хүрээнд чиглүүлэх зорилгоор жишээ болгон танилцуулж байгаа тул сэдвийг өөрсдийнхөөрөө томъёолж болно. "Хүүхэд, залуучуудын хөгжлийн асуудал, шийдэл, дэмжлэг"-ийн хүрээнд нарийвчлан томъёолсон сэдэв дээрээ ажиллах боломжтой.

Гурав. Илтгэлийн бүтцэд тавих шаардлага

Бага хуралд тавих илтгэл нь бүтцийн хувьд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Илтгэл нь хураангуй, түлхүүр үг, удиртгал, арга аргачлал, үр дүн, дүгнэлт, ном зүй, хавсралт гэсэн хэсгээс бүрдэнэ.
- Илтгэлийн хэмжээ А-4 цаасны 5-8 нүүр байна.
- Судалгааны материалуудыг хавсаргана.

Дөрөв.Илтгэлийн бичвэрт тавих шаардлага

Бага хуралд тавих илтгэлийн бичвэр нь дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

- Илтгэлийг А4 хэмжээтэй цаасны босоо форматтай нэг баганаар бичнэ.
- Гарчгийг Times New Roman – 12 том үсгээр, мөрний голд тодруулж бичнэ.
- Үндсэн бичвэрийн үсгийн фонт "Times New Roman, үсгийн хэмжээ нь 11, мөр хоорондын зай нь single, бичвэрийн хоёр талыг тэгшилсэн байна. Цаасны хэмжээ А4 /210x297 мм/, ашигтай талбайн хэмжээ /margins/ дээрээс 3 см, зүүн гар талаас 3 см, баруун гар талаас 2.5 см, доороос 3 см байна.
- Илтгэлд хууль, эрх зүйн баримт бичиг, судлаачдын бүтээлээс авсан зүйл, санааг эшлэлд авч, зүүлтийг АРА 7 загвараар хийнэ.
- Тоон боловсруулалтыг харуулсан хүснэгт, график, чанарын судалгааны хэрэглэгдэхүүн зэргийг оруулсан тохиолдолд нэр, тайлбарыг бичих ба хэт том хэмжээтэй хийхгүй.
- Илтгэлд эшилсэн бүх бүтээл ном зүйд орох бөгөөд ном зүйг хийхдээ АРА 7 загварыг ашиглана.

Тав. Илтгэл шалгаруулах шалгуур

Илтгэлийг шалгаруулахдаа доорх шаардлагуудыг тавих болно. Үүнд:

1. Тодорхой асуудлыг авч үзсэн эсэх
2. Сэдэвтэйгээ холбоотой онол, арга зүй, хууль эрх зүйн баримт бичгийг уншиж судалсан байдал
3. Судалгааны аргуудаа оновчтой сонгон, хэрэглэсэн байдал
4. Цуглуулсан мэдээлэлд тоон болон чанарын боловсруулалт хийж, тайлбарласан байдал
5. Судалгааныхаа үр дүнд тулгуурлан өөрийн үзэл бодлыг тодорхой илэрхийлж, үнэлгээ, дүгнэлт гаргасан байдал
6. Дэвшүүлж буй санал, шийдэл нь бодит байдалд нийцсэн байдал
7. Эх бичвэрт тавигдсан шаардлагуудыг хангасан байдал

Зургаа: Илтгэл хүлээж авах хугацаа ба тавих шаардлага

- Илтгэлийг 2024 оны 11-р сарын 07-ны 17.00 цаг хүртэл МУБИС-ийн хичээлийн 9-р байрны 21 тоотод эх хувиар хүлээн авч, бүртгэнэ.
- Илтгэлийг ганцаараа болон хоёр хүртэл хүний бүрэлдэхүүнтэй багаар гүйцэтгэж болно.
- Илтгэл нь урьд өмнө бусад эрдэм шинжилгээний хуралд тавигдаж, хэвлэн нийтлэгдээгүй байна.
- Бүртгүүлэхдээ илтгэлийн эхийг гурван хувь хэвлэж авчрах ба илтгэгчийн нэр, хаягийг эх материал дээр бичихгүй (шүүгчид зөвхөн кодолсон материал унших шаардлагатай тул). Илтгэгч өөрийн биеэр ирж бүртгүүлэхдээ код авч, нэр хаягаа бүртгэлийн хуудсанд бичүүлнэ.
- Илтгэлийн эхийг munkhtsetseq.n@msue.edu.mn хаягаар (электрон хэлбэрээр) заавал илгээнэ.
- Зохион байгуулах комисс 2024 оны 11 сарын 12-нд шалгарсан илтгэгчид утсаар хариу мэдэгдэнэ. Үүний дараа шалгарсан илтгэлийг бага хуралд хэлэлцүүлэхэд зориулсан презентэйшнийг Power Point программ дээр бэлтгэж, 2024 оны 11 сарын 12-13-нд удирдагч багшаасаа зөвлөгөө авч ажиллана.
- Хугацаа хоцорсон, шаардлага хангаагүй, бага хурлын сэдэвт хамаарахгүй сэдэв хөндсөн илтгэлийг хүлээн авахгүй.
- Хоёр дахь шатанд шалгарч, үндсэн хуралдаанд хэлэлцүүлэн, хэвлэлийн шаардлага хангасан илтгэлүүдийг БСС-аас эрхлэн гаргадаг Оюутны Эрдэм шинжилгээний илтгэлүүдийн V ботид хэвлэн нийтэлнэ.
- Эхний гурван байранд шалгарсан илтгэлийг “Нээлттэй” сургууль” сонинд хэвлэн нийтэлнэ.

Долоо: Эрдэм шинжилгээний хурлын зохион байгуулалт

Бага хурлыг зохион байгуулах үйл ажиллагаа нь дараах байдлаар явах болно. Үүнд:

- Илтгэлийг дээр дурдсан хугацаанд авч, комисс уншиж шалгаруулна.
- Зохион байгуулах комисс зөвхөн шалгарсан илтгэгчид утсаар хариу мэдэгдэнэ.
- Удирдагч багш нарын өгсөн зөвлөгөөний дагуу шалгарсан оюутнууд илтгэлээ сайжруулж, PPT бэлтгэнэ.
- Хуралд шалгарсан илтгэлийн бэлтгэсэн танилцуулгыг (PPT) эцсийн байдлаар 2024.11.15-ны 14.00 цаг хүртэл munkhtsetseg.n@msue.edu.mn хаягаар ирүүлнэ.
- Эрдэм шинжилгээний бага хурал 2024 оны 11 сарын 16-ний өдрийн 10.00-д МУБИС-ийн төв байрны 200 тоот өрөөнд болно.

Шагнал урамшил:

Тэргүүн байр 1 – Өргөмжлөл, үнэ бүхий зүйл (МУБИС, БСС)
Хоёрдугаар байр 1- Өргөмжлөл, үнэ бүхий зүйл (МУБИС, БСС)
Гуравдугаар байр 1- Өргөмжлөл, үнэ бүхий зүйл (МУБИС, БСС)
Тусгай байр 4- Өргөмжлөл, номын багц (БХАН)

**МУБИС, Боловсрол судлалын сургууль,
Боловсрол судлал, арга зүйн тэнхим,
Боловсролын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг**